


БАНКНЫ САЛБАРЫН ТОЙМ

2019 оны 2 дугаар улирал



БАНКНЫ САЛБАРЫН
МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО



 www.mba.mn




 facebook.com/MongolianBankersAssociation

 twitter.com/Mongolianbanker

 +976 11 323581

МӨНГӨНИЙ ЗАХ

2019 оны 2-р улирлын байдлаар мөнгөний нийлүүлэлт 20.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 17 хувиар өссөн байна. Мөн хугацаанд эдийн засгийн идэвхжилтэй холбоотойгоор валютын гадагшлах урсгал эрчимжиж, 2018 оны 2-р улирлаас хойш голлох валютын эсрэг төгрөгийн ханш тасралтгүй сулрав. 2018 онд Монголбанк 800 орчим сая ам.долларын интервенци валютын захад нийлүүлсэн бол 2019 он гарсаар 1.2 тэрбум ам.доллар буюу валютын нөөцийн 1/3-тэй тэнцэхүйц ам.доллар зах зээлд нийлүүлжээ. Энэ нь хүчтэй суларч байсан төгрөгийн ханшийг тогтворжуулахад нөлөөлж байна. 2019 оны 2-р улирлын байдлаар төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2654 төгрөгт хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үеэсээ 9 хувь сулраад байна. Гэвч бусад валютын эсрэг төгрөг үргэлжлэн суларсаар байна. Эдийн засаг 8.6 хувьтай өсч байгаа энэ үед инфляц төв банкны зорилтот түвшингээс давж байгаа нь асуудал болж байна. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш тогтворжсон. 2016 оны 2-р улирлаас буулгасан бодлогын хүүний нөлөөгөөр зээл болон хадгаламжийн хүү аажмаар буурсаар 2019 оны 2-р улирлын байдлаар харгалзан 16.9 хувь болон 11.5 хувь байна. Өөрөөр хэлбэл сүүлийн 2 жилийн хугацаанд зээлийн хүү 3 нэгж хувиар, хадгаламжийн хүү 1.4 нэгж хувиар буураад байна.



Эх сурвалж: Монголбанкны сарын статистикийн тоо мэдээллээс ашиглан жилийн өсөлтийг тооцон гаргасан.



Тэмдэглэл: Мөнгөний нийлүүлэлтийг бүтцээр нь авч үзвэл төгрөг болон валютын харилцах, хадгаламж болон банкнаас гадуурч бэлэн мөнгө бүрдүүлдэг.

Дээрх зурагт голлох өсөлтийг бүрдүүлэгч хадгаламжийг валютаар нь харуулсан болно. Валютын хадгаламжийн өсөлт нь төгрөгт итгэх итгэлийг харуулагч гол хувьсагч болдог. Өсөлтийн хурд нь нэмэгдэх нь төгрөгт итгэх иргэд, ААН-н итгэл суларч байна гэж ойлгогдоно.

БАНКНЫ ЭХ ҮҮСВЭР

Банкны секторын нийт эх үүсвэр өмнөх оны мөн үеэс 16.7 хувиар өсч 31.6 их наяд төгрөгт хүрлээ. Эх үүсвэрийн өсөлтөд харилцах болон хадгаламжийн өсөлт нь голлох хувь нэмрийг оруулж байна. Харилцах, хадгаламжинд валютын харилцах, хадгаламжийн эзлэх хувь буурах хандлагатай байгаа нь иргэдийн төгрөгт итгэх итгэл хадгалагдаж байгааг илэрхийлж байна. Нөгөө талаас Монголбанкнаас валютын заавал байлгах нөөцийг нэмэгдүүлсэн болон эрсдэлээр жигнэсэн активийн харьцааг өсгөсөн зэрэг нь долларжилт үүсэхээс сэргийлсэн арга хэмжээ болж байна. Мөнгөний зах зээлд долларжилт нэмэгдэх нь мөнгөний бодлогын хүүгийн нөлөөг бууруулах сөрөг нөлөөтэй.

Хадгаламж бүрийн жилийн өсөлтийг тооцоход валютын хадгаламж нь төгрөгтэй харьцах ам.долларын ханшийн хөдөлгөөнөөс хүчтэй хамаардаг нь харагдаж байна. Тухайлбал 2016 оны төгсгөлд төгрөгийн ханш ам.долларын эсрэг суларч байсан нь валютын хугацаагүй хадгаламж 80 хувиар өсөхөд хүргэв. Энэ нь нэг талаас төгрөгт итгэхгүй иргэдийн үйл хөдлөл бол нөгөө талаасаа богино хугацаанд ашиг хайх гэсэн зорилготой агентуудын үйл хөдлөл юм.





Эх сурвалж: Монголбанкнаас гаргадаг банкуудын дэлгэрэнгүй тайлан дээр үндэслэн дээрх тооцооллыг гаргав. Нийт хадгаламжийг хугацаатай, хугацаагүй гэж ангилах бөгөөд тус бүртээ төгрөг, валют гэж ангилагдаж байна.



БАНКНЫ АКТИВ

Банкны салбарын активын голлох хувийг зээл болон төв банкны үнэт цаас бүрдүүлж байна. Гэвч 2019 он гарсаар зээлийн өсөлтийн хурд хүчтэй саарч эхлэв. Активийн чанарын үнэлгээтэй холбоотой чанаргүй зээл өссөн бөгөөд эдийн засаг идэвхжсэн энэ үед хангалттай буухгүй байна.

Банкны актив өмнөх оны мөн үеэс 15 хувиар өсч, 34.7 их наяд төгрөгт хүрлээ. Өөрөөр хэлбэл Монголын эдийн засагтэй тэнцэхүйц активтай байна гэсэн үг. Активын голлох өсөлтийг зээл болон төв банкны үнэт цаас бий болгож байна. 2016 оны сүүлээс Сангийн яамнаас Засгийн газрын үнэт цаас гаргахыг зогсоосноор 2016 онд 3.6 их наяд төгрөг байсан бол 2019 оны 2-р хагаст 1.5 их наяд төгрөг болж буурчээ. Засгийн газрын үнэт цаасны арилжаа зогссоноор банкууд хөрвөх чадвараа хангахын тулд төв банкны үнэт цаасыг худалдан авч эхэлсэн. Улмаар 1 их наяд хүрэхгүй байсан төв банкны үнэт цаас 5 дахин нэмэгдэж, 4.7 их наяд төгрөгт хүрлээ.



Эх сурвалж: Монголбанкнаас гаргадаг банкуудын дэлгэрэнгүй тайлан дээр үндэслэн дээрх тооцооллыг гаргав.
Эрсдэлтэй зээлийн харьцаа гэдэг нь 90 хүртэлх хоног хугацаа хэтэрсэн зээлийг нийт зээлд харьцуулсан харьцааг хэлнэ.
Чанаргүй зээлийн харьцаа гэдэг нь 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн буюу чанаргүй зээлийг нийт зээлд харьцуулан тооцдог.




ШИНЭЭР ОЛГОСОН ЗЭЭЛ

Шинээр олгосон зээл 2019 онд зээлийн хязгаарлалттай холбоотой хүчтэй саарсан. Зээлийн чанарыг салбаруудаар авч үзвэл уул уурхай, барилга, боловсруулах салбарт зээлийн чанар муу байна. Сүүлийн 3 жилд Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалттай холбоотой уул уурхай, барилга, худалдааны салбарын зээлүүд 1-3 дахин өсчээ.

Шинээр олгосон зээлийн хэмжээ 2018 оны 4-р улиралд 7 их наяд хүрсэн нь Монголбанкны хэрэгжүүлэх зээлийн хязгаарлалтаас урьдах гэсэн иргэдийн үйл хөдлөл байв. 2019 он гарсаар хэрэглээний зээлд тавьсан хязгаарлалт хэрэгжиж эхэлснээр шинээр олгосон зээлийн өсөлт саарч, 2 хувьд хүрэв.

Чанаргүй зээлийн харьцаа үзүүлэлтийг салбаруудаар авч үзвэл хамгийн их хөшүүрэг шаарддаг уул уурхай, барилга, боловсруулах салбаруудад зээлийн чанар муу байна. Тухайлбал уул уурхайн салбар нь хил гааль, тээвэр, үнийн гэрээ гэх мэт олон хүчин зүйлсээс шалтгаалан эргэн төлөлтөд нь саад учирдаг. Барилгын салбар ч мөн адил борлуулалт хийхэд хугацаа шаарддаг, бэлтгэн нийлүүлэгчид нь давхар зээлтэй байдаг гэх мэтээр бие биетэйгээ гинжин хэлхээтэй. Энэ нь зээлийн чанаргүйдэл өндөр байхад хүргэдэг.

Олгосон зээлийн үнийн дүнгээр нь харвал худалдаа, уул уурхай болон барилгын салбарт олгосон зээл сүүлийн 3 жилд бараг 1-3 дахин өсчээ. Ийнхүү өссөн шалтгаан нь Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалттай холбоотой дотоодын бэлтгэн нийлүүлэгчдэд хөрөнгө оруулалт шаардлагатай болсон ба тэрхүү хөрөнгө оруулалтыг банк санхүүжүүлсэн гэсэн үг. Тухайлбал цементийн хэрэглээний 60 хувь нь Оюутолгойд нийлүүлэгдэж байна. Худалдааны салбарын ихэнх худалдан авалт нь уул уурхайн тоног төхөөрөмж байна. Харин боловсруулах болон ХАА-н салбарт төдийлөн зээл олголт нэмэгдээгүй байна.




Эх сурвалж: Монголбанкнаас гаргадаг банкуудын дэлгэрэнгүй тайлан дээр үндэслэн дээрх тооцооллыг гаргав. Салбар бүрийн чанаргүй зээлийг салбар бүрийн нийт зээлийн үлдэгдэлд харьцуулснаар тухайн салбарын чанаргүй зээлийн харьцаа гарч ирнэ.


СИСТЕМИЙН НӨЛӨӨ БҮХИЙ 5 БАНК

Банкны салбарт системийн нөлөө бүхий 5 банкны актив, зээл, чанаргүй зээл, харилцах, хадгаламж, өөрийн хөрөнгө болон ашиг, алдагдлыг харьцуулав. Харилцах, хадгаламж хурдацтай өссөн нь эдийн засгийн идэвхжил өндөр байгаатай холбоотой. Харин хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой чанаргүй зээл өссөн. Мөн тус үнэлгээний үр дүнд банкуудын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх шаардлага тавигдсан бөгөөд банкууд энэхүү шаардлагын дагуу өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэв.

Банкны актив, жил бүрийн 2-р улирал



Зээлийн үлдэгдэл, жил бүрийн 2-р улирал



Чанаргүй зээл, жил бүрийн 2-р улирал






Хадгаламж, жил бүрийн 2-р улирал



Эх сурвалж: Банк бүрийн мэдээллийн сайтын санхүүгийн тайлан гэсэн хэсгээс 2017, 2018, 2019 оны 2-р улирлын мэдээллийг авч ашигласан болно.

Санхүүгийн балансаас актив, зээл, чанаргүй зээл, харилцах, хадгаламж болон өөрийн хөрөнгийн мэдээллийг авсан бол татварын дараах ашиг, алдагдлыг орлогын тайлангаас авсан болно.

17A, 18A, 19A гэдэг нь 2017, 2018, 2019 он тус бүрийн тоон бодит утгыг илэрхийлнэ.



Эх сурвалж: Банк бүрийн мэдээллийн сайтын санхүүгийн тайлан гэсэн хэсгээс 2017, 2018, 2019 оны 2-р улирлын мэдээллийг авч ашигласан болно.


Санхүүгийн балансаас актив, зээл, чанаргүй зээл, харилцах, хадгаламж болон өөрийн хөрөнгийн мэдээллийг авсан бол татварын дараах ашиг, алдагдлыг орлогын тайлангаас авсан болно.

17A, 18A, 19A гэдэг нь 2017, 2018, 2019 он тус бүрийн тоон бодит утгыг илэрхийлнэ.


БАНКНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өөрийн хөрөнгийн харьцаа: Санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс сэргийлж банкны хувьцаа эзэмшигчид тодорхой хэмжээний хөрөнгийг Монголбанкинд бэлнээр байршуулдаг. Энэхүү өөрийн хөрөнгийн хувь нь активын 14 хувиас доошгүй байх шаардлагатай.

Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа, 2019Q2




1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа, 2019Q2



Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар: Харилцагч богино хугацаанд их хэмжээний мөнгө шаардлагатай болоход тухайн цаг мөчид нь гаргаж өгч чадах уу? гэдэг нь банкуудын хувьд чухал байдаг. Тиймээс энэ эрсдэлээс сэргийлэхийн тулд активын 25 хувиас их байх хэрэгтэй. Энэхүү шаардлагыг бүх банкууд хангаж байгаа юм.

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт, 2019Q2



Эх сурвалж: Банк бүрийн мэдээллийн сайтын санхүүгийн тайлан гэсэн хэсгээс 2019 оны 2-р улирлын мэдээллийг авч ашигласан болно.